



“САУС РЕСУРС” ХХК-ИЙН ДОРНОГОВЬ
АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГТ
ХЭРЭГЖИХ “ХАЯГДАЛ ТОС ДАХИН
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 3317625/




ГАРЧИГ

Төслийн ерөнхий мэдээлэл.....	2
1. 1.2 Төслийн хүчин чадал	3
ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	5
ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	10
2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	12
3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	14
4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	14
5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	15
6. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	16
7. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ.....	19
8. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	20
9. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)	21

ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр: “Хаягдал тос дахин боловсруулах үйлдвэр” төсөл
Төсөл хэрэгжүүлэгч: Саус ресурс ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 0611007072
Регистрийн дугаар: 3317625
Хаяг, байршил: Дорноговь, Сайншанд, 4-р баг, дунд буянт ухаа, 6-9.
 Утас:88026461
Газар ашиглах зориулалт Хаягдал тос дахин боловсруулах
Ашиглах талбай: 1 га
Төслийн байршил: Дорноговь аймгийн Сайншанд сумын 3-р баг, төвлөрсөн хогийн цэгийн урд талд байрлана.
Хүснэгт 1 Хайгуулын талбайн сольбилцол

Д/д	Х	Ү	Талбайн хэмжээ
1	434967.50	4970542.10	1 га
2	435028.76	4970463.06	
3	434949.72	4970401.80	
4	434888.46	4970480.85	



Зураг 1 Байршлын зураг (Google earth)

Хүснэгт 2 Техник эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлтүүд		Тодорхойлолтууд		
A	Ерөнхий мэдээлэл			
1	Аж ахуйн нэгжийн нэр	“Саус Ресурс” ХХК		
2	Үйлдвэрийн нэр	Дахин боловсруулах үйлдвэр		
3	Тусгай зөвшөөрлийн дугаар			
Б	Техникийн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Хэмжээ	
1	Жилийн хүчин чадал	Тонн		
	- Бүгд			
	- Ердийн дизель түлш		3000	
	- Мазут		1600	
2	Үндсэн материал, анхдагч эдийн хувийн зарцуулалт	КВ/цаг МЗ/цаг Кг Кг		
	- Цахилгаан эрчих хүч			
	- Түүхий эд		200-250	
	- Бодисын зарцуулалт			
	- Нүүрсний зарцуулалт			
В	Эдийн засгийн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Хэмжээ	
1	Хөрөнгө оруулалт	900 000 000 ₮		
2	Борлуулалтын нэгж үнэ	төг		
	- Дизель түлшний үнэ		1500	1500
	- Мазут үнэ		100	100
3	Шинээр бий болох ажлын байр		9	14

1. Төслийн хүчин чадал

Хаягдал тос боловсруулах үйлдвэрийн хүчин чадал жилд 5500 тонн байхаар ТЭЗҮ-д тусгасан болно.

Эко үйлдвэрээс жилд 3000 тонн дизель түлш, 1600 тонн мазут гэсэн үндсэн хоёр төрлийн бүтээгдэхүүн гарах бөгөөд хаягдал 180 тонн лаг гарна.

“Саус Ресурс” ХХК-нийн дахин боловсруулах үйлдвэрийн төсөл хэрэгжсэнээр:

- Бүс нутагт хаягдаж буй 5500 тонн хаягдал тосыг боловсруулна.
- Улсын төсвийн орлогод хувь нэмрээ оруулна.
- Дотоодын нийт бүтээгдэхүүн бага хэмжээгээр өснө.
- Шинэ техник технологи нэвтэрнэ.
- Шинэ ажлын байр нэмэгдэнэ.
- Чадварлаг боловсон хүчин бэлтгэгдэнэ.
- Дотоодын зах зээл дэх бараа, бүтээгдэхүүн ажил үйлчилгээ нэмэгдэнэ.

Дахин боловсруулах үйлдвэрийн технологийн үндсэн бүтээгдэхүүний гарц нь үйлдвэрийн зураг төсөлд санал болгож буй технологийн горим, түүхий эдийн чанар, үйл ажиллагаанаас голлон хамаарч 54%-ийн гарцтай үндсэн бүтээгдэхүүн дизель үйлдвэрлэнэ. Дайвар бүтээгдэхүүн болох М-100 маркийн мазут 30% үйлдвэрлэх бөгөөд 10-15% нь усны уур, 5-8% нь шатдаг хий гаргах юм. Манай үйлдвэр нь хаягдал моторын тосноос гадна түүхий нефтийг боловсруулах бүрэн боломжтой бөгөөд 65-70% гарцтай үндсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Тус төслийн бүтээгдэхүүний гарцыг үйлдвэрийн үндсэн хүчин чадлын 70% байхаар тооцож боловсруулав.

ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ХҮЧИН ЧАДАЛ, ТЕХНОЛОГИЙН ҮНДСЭН ШИЙДЭЛ

Дахин боловсруулах үйлдвэрийг Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт байгуулах бөгөөд үйлдвэрийн үндсэн барилга болон түүнтэй ойрхон хэд хэдэн барилга байгууламжаас бүрдэнэ. Үүнд:

- Дахин боловсруулах үйлдвэр
 - ✓ Бодис урвалжийн хэсэг
 - ✓ Ажилчдын өрөө
 - ✓ Хяналтын хэсэг
- Засвар үйлчилгээний хэсэг
- Сэлбэгийн агуулах
- Лаборатори
- Албан контор,

Дахин боловсруулах үйлдвэр нь тасралтгүйгээр 25 хоног ажиллах бөгөөд 12 цагийн 2 ээлжээр ажиллана. 3 хоногт өдрийн цагаар засвар үйлчилгээ хангамжийн ажил хийгдэж 2 хоног амарна. Эндээс үйлдвэрийн ажиллах горимыг гаргасан. Төслөөр үйлдвэрийн жилд ажиллах хугацаа нь 6000 цаг байна.

Үйлдвэрийн ажиллах горим:

- ✓ Хуанлийн хоног жилд 365 хоног
- ✓ Амралтын өдрүүд жилд 84 хоног
- ✓ Засвар үйлчилгээ жилд 36 хоног
- ✓ Үйлдвэрийн ажиллах боломжит хоног 245 хоног
- ✓ Үйлдвэрийн жилд ажиллах боломжит цаг 7400 цаг
- ✓ 90%-ийн ашиглалтын коэффициентээр тооцвол 6600 цаг
- ✓ 90%-ийн тооцооллын боломжоор тооцвол 6048 цаг

Төслийн жилд ажиллах зорилтот хугацаа 6000 цаг

Үйлдвэр нь төлөвлөж байгаагаар 2 үндсэн үе шаттайгаар цаашид өргөтгөх боломжит талбайтай зохион байгуулахаар явагдана.

ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл:

Монгол улсын засаг захиргааны хуваариар Монгол орны зүүн урд хэсэгт буюу Дорноговь аймгийн төв Сайншандад байрлана. Тус үйлдвэрийн талбай нь Сайншанд сумаас 8 гаруй км зайтай.

Гадаргуугийн хувьд ерөнхийдөө нам уулс, жижиг толгод, талархаг гадаргуу зонхилох ба далайн төвшнөөс дээш дунджаар 938 м өргөгдсөн. Дорноговь аймаг нь Монголын зүүн өмнөд хэсгийн талархаг гадаргатай хэсэгт оршдог. Гэхдээ энд Хутаг уул (1431м), Оцол, Сансар, Их, Багадулаан, Аргалант, Хан Баянзүрх хайрхан (1031м) зэрэг уулууд бий, Нутгийн дундуур зүүн хойшоо баруун урагшаа их хотгор газар үргэлжилнэ. Хамгийн нам дор газар Баянгийн говь далайн түвшнээс дээш 703 метр өндөрт оршино. Нутгийн өмнөд хэсгээр бага зэрэг элстэй¹.

Уур амьсгал:

Төслийн талбай нь эх газрын эрс тэс, хахир ширүүн, чийглэгдүү сэрүүн, нэн хүйтэн уур амьсгалын ангид хамаарагдана.

Тус нутагт өвөл нь хүйтэн бөгөөд удаан үргэлжилдэг. Зун нь богино, халуун болдог. Хавар, намрын улиралд цаг агаар тогтворгүй эрс өөрчлөгдөж байдаг. Жилийн хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж агаарын температур -18.2°C хүйтэн, үнэмлэхүй хамгийн бага агаарын температур -41.4°C хүрч хүйтэрсэн байна. Өвөлдөө 7.7 мм хур тунадас унадаг. Жилийн хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж агаарын температур 23.1°C байдаг. Энэ улиралд жилийн хур тунадасны дийлэнх хэсэг нь 88% буюу 99.4 мм нь ордог. Агаарын үнэмлэхүй хамгийн их температур 41.6°C хүрч халсан байна.

Сайншанд орчмын нутгаар жилдээ дунджаар 3338 цаг нар гийгүүлдэг. Нар гийгүүлэх хугацаа өвөлдөө бага 256 цаг, зундаа их 309 цаг байдаг. Жилийн дундаж нийлбэр цацраг тус аймгийн нутгаар 434.5 мДж/м^2 байдаг.

Геологийн тогтоц ба геоморфологи:

Төсөл хэрэгжих нутаг нь геологийн тогтцын хувьд төдийлөн нарийн нийлмэл бус бөгөөд ерөнхий төрх байдал дэлхийн царцдасны гадаад хүчний үйлчлэлийн үр дүнд бий болсон бөгөөд энэ нутгийг хамарсан геологийн бүрдлүүд нь урт удаан хугацааны эрин галавын туршид үүсэж, янз бүрийн геодинамикийн болон геотектоникийн нөхцөлийг дамжин өөрчлөгдөн хөгжиж ирсэн байна.

Цэрдийн галавт үүссэн галт уулын болон тунамал гаралтай чулуулгууд Монгол орны өмнөд хэсэгт, ялангуяа Говийн бүсэд өргөн тархалттай. Сайншанд сумын ойролцоо доод Цэрдийн Хөхтээг, дунд Цэрдийн Баянширээ (K2bs), Баруунгоёт (K2bg) формацууд ангилагддаг байна.

Газрын доорх ус:

Гидрогеологи: “Танан Импекс” ХХК нь 2012 онд Сайншанд хотоос зүүн хойш 35-40 км зайд орших Бор Хөөврийн хөндийд ундарга сайтай ($Q=25-28 \text{ л/с}$) 5 худаг гаргасан байна. Мөн 1986-1988 онд Бор Хөөврийн говийн нийт талбай (баруун талын “Загийн говь” буюу “Сайн усны говь” зүүн талын “Бор Хөөврийн говь хэсэгчилсэн зурвас”) -д гидрогеологийн эрэл, урьдчилсан хайгуулын ажил явуулсаны үр дүнд дээд цэрдийн Баянширээгийн давхраадсын тунамал хурдасны зузаалагт тархсан газрын доорх усны ордын ашиглалтын нөөцийг үйлдвэрлэлийн В, С1 ба хэтийн төлөвийн (үйлдвэрлэлийн бус) С2 зэргээр тогтоож үнэлсэн байна. Ийнхүү В зэргийн нөөц 93 л/с буюу $8.035 \text{ м}^3/\text{хоног}$, С1-ээр 230 л/с буюу $19.872 \text{ м}^3/\text{хоног}$, С2-оор 428 л/с буюу $36.979 \text{ м}^3/\text{хоногоор}$ тус тус үнэлэгдсэн байна.

Төслийн районд тархсан хурдас чулуулгийн давхарга зүйчлэлээр дараах уст цогцолборыг ялгаж

болно. Үүнд:

- Аллюви-пролювийн гаралтай неогены уст цогцолбор (арQ1, арQ2)
- Дээд цэрдийн Баруунгоёотын уст цогцолбор
- Дээд цэрдийн Баянширээгийн уст цогцолбор

Нийт ус хураах талбайн хэмжээ 180,555 км², гадаргын усны байнгын урсацгүй, газрын доорх усны нөөцтэй сав газрын хэв шинжэд хамаардаг. Газрын доорх усны баримжаат нөөц 433 сая.м³, ашиглалтын нөөц 46.7 сая.м³.

Хөрсөн бүрхэвч:

Дорноговь аймгийн Сайншанд сумын 3-р багийн нутагт баригдах “Саус ресурс” ХХК-ний эзэмшил талбайн хөрс нь Монгол орны хөрс газарзүйн мужлалаар авч үзвэл Бор хөрсний дэд мужийн Дорноговийн 12-р тойрогт хамрагддаг. Судалгааны бүс нутаг нь цөлөрхөг хээрийн бүсэд байрлах учир Бор хөрс тэр дундаа мараалаг Бор болон элсэн хучаастай мараалаг Бор хөрсний төрлүүд, дангаар болон бүрдэл байдлаар тархсан байна.

Ургамалан нөмрөг:

Ургамалжлын хувьд Цөлөрхөг хээрт 3 зүйл Хялгана (*Stipa gobica*, *S. glareosa*, *S. brevifolia*), 1 зүйл Хазаар өвс (*Cleistogenes songarica*), Таана (*Allium polyrhizum*), сөөгнөөс 4 зүйл Харгана (*Caragana pygmaea*, *C. leucophloea*, *C. bungei*, *C. korshinskyi*), Орог тэсэг (*Krascheninnikovia ceratoides*) болон заримдаг сөөгөнцөр шарилжууд (*Artemisia rutifolia*, *A. xanthochloa*, *A. santolinifolia*, *A. pycnantha*) болно. Бусад заримдаг сөөгөнцөрүүд (*Artemisia frigida*, *A. caespitosa*, *A. xerophytica*, *Anabasis brevifolia*, *Salsola passerina*, *Convolvulus gortschakovii*, *Ajania achilloides*, *A. trifida*, *Reaumuria songarica*, *Asterthamnus heteropappoides*) дэд зонхилно. Дагуул зүйл ургамлууд нь заримдаг сөөгөнцрөөс *Oxytropis aciphylla*, *Ptilotrichum canescens*, *Kochia prostrata*, алаг өвснөөс *Allium mongolicum*, *Gypsophila desertorum*, *Convolvulus ammannii*, *Lagochilus ilicifolius*, *Scorzonera divaricata*, *Aster hispidus*, *Asparagus gobicus* зэрэг бол, цөөн настаас *Salsola pestifera*, *S. collina*, *Artemisia scoparia*, *Neopalassia pectinata* зэрэг ургамлууд болно.

Амьтны аймаг:

Төслийн талбай нь Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт хамаарах бөгөөд амьтны газар зүйн мужлалаар Монгол дагуураас Хойт говийн тойрог руу шилжсэн бүсэд байрлаж байгаараа онцлог юм. Амьдрах орчны хувьд бүхэлдээ тал хээрээс цөлөрхөг хээрт шилжих завсрын хэв шинж ажиглагдана. Төслийн талбайн амьтны аймгийн зүйлийн бүрдлийг хээрийн судалгааны материал, холбогдох ном, сурвалж, зэргэлдээх уурхайн байгаль орчны судалгаа, мониторингийн тайланд тулгуурлан боловсрууллаа. Үүнд 25 зүйлийн хөхтөн, 100 гаруй зүйлийн шувуу (нүүдлийн шувууд орсон тоо), 7 зүйлийн мөлхөгч амьтан тохиолдох боломжтой байна.

Тусгай хамгаалалттай газар нутаг:

Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт Улсын тусгай хамгаалалтад авсан 8 газар байдаг. Үүнд:

- Дархан цаазат газар 1
- Байгалийн нөөц газар 6
- Дурсгалт газар 1 болно.

Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт нийт 776777.87 га талбай Улсын тусгай хамгаалалтад байдаг ба нийт нутаг дэвсгэрийн 7%-ийг эзэлж байна. Төслийн талбайгаас Бүрдэнэ булаг БНГ 94.3км, Их нарт БНГ 109км, Арваннайманы Богд уул БНГ 143.6км, Эргэлийн зоо БНГ 186.8км зайд байрлана.

Нийгэм, эдийн засаг:

Нийгэм, эдийн засгийн хувьд Хилийн байнгын үйл ажиллагаатай Замын-Үүдийн, улирлын ажиллагаатай Баянбулаг-Мандалын боомтуудтай. “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс байгуулах эрх зүйн орчин бүрдсэнээр Монгол улсын хөгжил дэвшлийн нэгэн үүд хаалга болж хөгжих ирээдүйтэй. Тус аймагт ЭМШИУС-ын Дорноговь аймаг дахь салбар сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Төмөр замын МСҮТөв, Ерөнхий боловсролын 23 сургууль, 17 дотуур байр, 21 цэцэрлэг, эрүүл мэндийн 72 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон нийгэм, эдийн засагт үзүүлэх болзошгүй нөлөөллийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх зорилгоор авах арга хэмжээний чиглэлийг тодорхойлсон болно.

Хүснэгт 3 Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл

АГААРЫН ЧАНАР	
Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл: ✓ Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног, төхөөрөмжийг тээвэрлэх, сууриулах явцад тоосжилт ихээр үүсэх; ✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх;	Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж: ✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэхээс сэргийлж зам талбайн усалгааг сайтар хийх; ✓ Автозамаас үйлдвэр хүртэл 1 км хатуу хучилттай зам тавих;
УСАН ОРЧИН	
Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл: ✓ Төслийн үйл ажиллагаанд ашиглах усны хэмжээгээр газрын доорх усны нөөц багасах; ✓ Ахуйн бохир усыг ил задгай хаясанаар хөрсний ус бохирдох; ✓ Хатуу болон нефтийн бүтээгдэхүүний хаягдлыг тусгайлсан цэгт хаяагүйн улмаас хөрсөнд нэвчилт үүсэх, ул хөрсний усыг бохирдуулах;	Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж: ✓ Төслийн үйл ажиллагаанд ашиглах боломжит усны нөөцөөс хэтрүүлэхгүй байх; ✓ Ахуйн шингэн хаягдлыг ил задгай асгахгүй байх, зориулалтын цэгт хаяж байх; ✓ Хаягдал хуримтлуулах цэгийг стандартын дагуу шийдвэрлэх;
ГАЗРЫН ГАДАРГА БОЛОН ХӨРСӨН БҮРХЭВЧ	
Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл: ✓ Хаягдал тос хүлээн авах байгууламжийг оновчтой төлөвлөөгүйн улмаас тос асгарах, хөрсөнд нэвчих ✓ Хатуу хучилттай зам барих хүртэл газрын гадарга эвдрэлд өртөх болон хөрсөн бүрхэвч доройтох; ✓ Үйлдвэр, лаборатор, ажилчдын тосгон	Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж: ✓ Төслийн барилга байгууламж баригдаж эхэлхээс өмнө сайжруулсан шороон замыг ашиглалтад оруулах, төслийн үйл ажиллагаа эхэлхэд хатуу хучилттай автозамыг ашиглалтад оруулах; ✓ Төслийн талбайд маршрут гарган бусад
- зэрэг барилга байгууламжийн нөлөөгөөр газрын хэвлий болон хөрсөн бүрхэвч чанараа алдах; ✓ Төслийн дотоод зам, талбай болон гадна талбайд олон салаа зам гаргахгүй байх;	- хэсгээр тээврийн хэрэгслийг зорчуулахгүй байх; ✓ Тээврийн хэрэгслийн зогсоол, ногоон байгууламжийг зөв оновчтой төлөвлөх;
УРГАМАЛАН НӨМРӨГ	

Төслийн үйл ажиллагаанаас ургамалан нөмрөгт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл: ✓ Хатуу хог хаягдлыг тусгайлсан цэгт хаяагүйн улмаас ургамалан нөмрөг шинж чанараа алдах; ✓ Төслийн талбайд тээврийн хэрэгсэл, хүний үйл ажиллагаанаас ургамал ургаж буй газруудыг талхлагдалд оруулах; ✓ Ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүдээс нефтийн бүтээгдэхүүн алдагдаж, ургамалан нөмрөгийг гэмтээх, бохирдуулах; ✓ Хаягдал тосыг тээвэрлэх, түр хадгалах байгууламж руу нийлүүлэх явцад асгарах, ургамалан нөмрөгийг хордуулах, ургамал үхжих;	Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж: ✓ Төслийн дотоод талбайд ногоон байгууламжийг оновчтой төлөвлөх; ✓ Хог хаягдлыг тогтсон нэг цэгт байршуулах; ✓ Түлш, шатах тослох материалыг ашиглаж буй орчинд тэдгээрийг нэвтэрч шүүрүүлэхгүй байх арга хэмжээг авч ажиллах; ✓ Төслийн эдэлбэр газраас бусад талбайн ургамлыг хамгаалахын тулд тогтсон нэг маршрутын дагуу явах; ✓ Машин механизм, тээврийн хэрэгслийн нэгдсэн зогсоол, засвар үйлчилгээний зориулалтын талбай гарган орчны ургамлын талхлагдахаас сэргийлэх;
АМЬТНЫ АЙМАГ	
Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл: ✓ Дуу чимээний нөлөөгөөр ан амьтад дайжих, амьдрах орчин нь өөрчлөгдөх; ✓ Тээврийн хэрэгслийн тоосжилтоос мал, амьтанд сөргөөр нөлөөлөх;	Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж: ✓ Төслийн лицензийн талбайн хязгаарыг хэтрүүлэхгүй байх; ✓ Үйл ажиллагааны явцад улирлаар нүүдэллэн ирдэг амьтдын байрших гол газрууд болон коридор нутагт тэдгээр амьтдыг хамгаалах, тоо толгойг нэмэгдүүлэхэд чиглэсэн биотехнологийн иж бүрэн арга хэмжээг хэрэгжүүлэх талаар орон нутгийн болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, туслалцаа үзүүлэх; ✓ Амьтны аймгийг хамгаалахын тулд судалгаа шинжилгээ, сургалт сурталчилгаа, хяналт шалгалтын олон талт арга хэмжээг орон нутгийн холбогдох байгууллагууд, иргэдтэй хамтран цогцоор хэрэгжүүлэх;
НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ	
Төслийн үйл ажиллагаанаас нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөлөл: ✓ Шинээр ажлын байр бий болох; ✓ Улс, орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх; ✓ Татварын орлого өсөх; ✓ Бүс нутагт хаягдаж буй хаягдал тосыг эргэлтэд оруулах; ✓ Дотоодын нийт бүтээгдэхүүн өсөх боломж нэмэгдэх; ✓ Шинэ техник технологи нэвтрэх; ✓ Чадварлаг боловсон хүчин бэлтгэгдэх;	

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгасан агуулга бүтэцтэй байх шаардлагатай.

Төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 2-р хэсэгт тусгасны дагуу, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэрэгт тулгуурлан боловсруулав.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 2.2-т заасны дагуу Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний ажлын үр дүнгээр боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үнэлгээний мэргэжлийн зөвлөл хэлэлцэн баталснаас хойш төсөл хэрэгжүүлэгч 1 сарын дотор тухайн жилийн БОМТ-гөө боловсруулан ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад батлуулахаар хүргүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгч “Саус ресурс” ХХК нь үйл ажиллагаандаа Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг дагаж мөрдөнө.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө		Нийт зардал
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө	1850,0
		Ногоон байгууламжийн төлөвлөгөө	140,0
		Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	300,0
		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2000,0
		Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	500,0
2	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1760,0
Нийт зардал			6550,0

2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

дд	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ, хэмжээ	Нэгжийн өртөг, мян.төгрөг	Нийт зардал, мян.төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын чанар							
1	Реакторын галлагааны үед нүүрс, мод зэргийг ашиглах учраас агаар орчинд утаа хаягдаж болзошгүй	Реакторын галлагаа явуулах газрын ойролцоо агаарын чанарыг тогтмол байдлаар хэмжих (NOx, SO ₂ , CO ₂)	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.	-	-	2025	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2008 MNS 4585:2016
2	Тээвэрлэлтийн явцад автомашины хөдөлгүүрийн шаталтаас агаарын чанарт нөлөөлөх	Автомашины агаар бохирдуулсны төлбөрийг төлөх	Жилд 3 удаа	-	150.0	2025	
Усан орчин							
1	Үйлдвэрийн зориулалтаар болон ахуйн зориулалтаар ашиглах ус нь гүний ус болон гадаргын усны нөөцөд нөлөөлөх	Төслийн усны хэрэгцээг орон нутгийн ус түгээх газраас тогтоосон үнэ тарифаар худалдаж авах , зөөвөрлөх	Ахуйн бол 7 хоногт 1 удаа Үйлдвэрийн бол Сард нэг удаа			2025	Ундны усны эрүүл ахуй, чанарын хяналт MNS 0900:2018 Ус хангамжийн эх үүсвэр сонгоход тавигдах шаардлага MNS 0899:1992
2	Үйлдвэрийн дамжлагын явцаас бодис, бүтээгдэхүүн алдран хөрсөөр дамжин гүний усыг бохирдуулж болзошгүй	Үйлдвэрийн шат дамжлага бүрийн багаж төхөөрөмжийн шалгалтыг тогтмол явуулах	7 хоногт 1 удаа	-	-	2025	
Хөрс ба ургамал							
1	Хүнд даацын машин механизм, түүний тээвэрлэлт, засвар үйлчилгээний газарт бохирдол үүсэх, шатах, тослох материал, нефтийн	Автомашины засварын газрыг тусгайлан байгуулах, тээвэрлэлт явуулах үед түүхий эд, Бүтээгдэхүүн бодис зэрэг нь алдрахаас сэргийлж үзлэг шалгалтыг тогтмол явуулах	Үйлдвэрийн дотоод зардлаар, Төслийн эхэнд	-	-	2025	Хөрс хамгаалах,

“Саус ресурс” ХХК-ийн Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт хэрэгжих “Хаягдал тос дахин боловсруулах үйлдвэр” төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

дд	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ, хэмжээ	Нэгжийн өртөг, мян.төгрөг	Нийт зардал, мян.төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулах	Бохирдол үүсэж болох цэгүүдэд тогтмол хугацаанд шинжилгээ явуулах	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.	-	-	2025	цөлжилтөөс хамгаалах тухай хууль, 2012 оны 5 сарын 17 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008
2	Хүн амын суурьшил нягтарснаас хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол үүсэх.	Хөрсний эвдрэлээс сэргийлж, явган хүний зам, талбайг барьж байгуулах	Дотоод зардлаар, Төслийн эхэнд	-	500.0	2025	
		Бие засах газар	Дотоод зардлаар, Төслийн эхэнд	-	500.0	2025	
		Хог хаягдал хаях ангилан ялгах цэг байгуулах	Төслийн эхэнд 1 удаа		200.0	2025	
3	Тээврийн хэрэгслийн зорчих хэсэг, үйлдвэрийн барилга байгууламжийн талбайн хэмжээгээр ургамлын бүрхэвчгүй болох, хөрс эвдрэлд өртөх	Олон салаа зам гаргахаас сэргийлэн тэмдэгжүүлэлт хийх	Төслийн эхэнд		500.0	2025	
Нийт					1850,0		

3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Тус төсөл хэрэгжих явцад тээвэрлэлт болон хүний үйл ажиллагааны улмаас тоосжилт үүсэх, хөрс эвдрэлд өртөж болзошгүй учраас үйл ажиллагааны ашиглалтын зөвшөөрөл бүхий 1.0 га талбайн 20%-тай тэнцэх талбайд говийн бүсэд тохиромжтой модлог ургамлын суулгац суулгахыг нөхөн сэргээлтийн арга хэмжээнд тусгалаа.

Цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Ногоон байгууламжийн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Орчны тоосжилтыг бууруулах, үйлдвэрийн байрны ногоон талбайг сайжруулах үүднээс ногоон байгууламж байгуулах	Нийт төслийн 20 %-д буюу 0.2 га-д улиангар, улиас, хайлаас тарих	Намрын улиралд Газар хөлдөхөөс өмнө	Улиас /70 см/ - 4500 ₮ Хайлаас /50-100 см/ - 4500 ₮	10 ширхэг /Улиас/ * 4500₮= 45,0 10 ширхэг /Хайлаас/ * 4500₮= 45,0 Зүлэгжүүлэлт хийх 50,0	140,0	Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2023
нийт				140,0		

4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Төсөл хэрэгжиж буй барилга байгууламжид	-	-	2025 Жилд 1 удаа	- Гамшгаас хамгаалах тухай хууль MNS 4992:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. MNS 5566:2020 Аж ахуй нэгж, байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм. MNS ISO 13688:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага MNS 3438: 1983 Хоёрдогч түүхий эд өнгөт төмөрлөгийн Техникийн ерөнхий нөхцөл,
	Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Бүх ажилчдад	100,0	100,0		
	Болзошгүй гал түймрийн аюулаас сонор сэрэмжтэй байх үүднээс хэрэгцээт газруудад тэмдэг, тэмдэглэгээ,багаж хэрэгслүүдийг байршуулах	Үйлдвэрийн барилга байгууламж	100,0	100,0		
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Бүх ажилчдад	100,0	100,0		
Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гэнэтийн болзошгүй байдлаар үйлдвэрт осол аваар гарах, тоног төхөөрөмж эвдрэх, ажилчид цахилгааны хүчдэлд цохиулах, түлэгдэх	Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрдүүлж бэлэн байлгах. Гал түймрийн үед авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллагсдад сургалт зохион байгуулах. Галын аюулын талаар анхааруулга самбарыг эзэмшлийн объект бүрд онцлогийг нь тусган тавих зэрэг арга хэмжээг авах шаардлагатай.	Үйлдвэрийн барилга байгууламж		Үйл ажиллагааны зардалд тусгах		Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага MNS 3438: 1983 Хоёрдогч түүхий эд өнгөт төмөрлөгийн Техникийн ерөнхий нөхцөл,
	Үйлдвэрийн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Үйлдвэрийн ажилчид		Үйл ажиллагааны зардалд тусгах		
Химийн бодисын асгаралд	Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, асгаралд болсон тохиолдолд саармагжуулах хэрэгслийг байрлуулах.	Үйлдвэрийн талбай		Үйл ажиллагааны зардалд тусгах		

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	/элс хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг					4. Хөдөлмөр хамгаалал аюулгүй техникийн шаардлага
Нийт		300,0				

6. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

“Саус ресурс” ХХК нь үйл ажиллагаанаасаа гарч буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах 3R зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай.

- ✓ Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 8.1.9.б-д заасны дагуу энгийн хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэхээр бүртгүүлж дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулан зөвшөөрөл авах;
- ✓ Үйлдвэрийн түүхий эд болох хог хаягдлыг өөрсдөө тээвэрлэх тохиолдолд хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарийг тогтоож, дүүргийн Засаг даргаар батлуулж мөрдөнө
- ✓ Сэргээн ашигласан, дахин боловсруулсан, устгасан, булшилсан хог хаягдлын бүртгэл хөтөлж мэдээллийн сан бүрдүүлнэ
- ✓ Хог хаягдлыг багасгах, хянах дотоод журам боловсруулах
- ✓ Хогийг анхан шатанд нь ангилан, ялгаж дахин ашиглах боломжтой хог хаягдлын хувь хэмжээг нэмэгдүүлж ажиллах.
- ✓ Аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын баталсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ыг мөрдөж ажиллах
- ✓ Үйлдвэрийн гадна болон дотор талбайд ангилан ялгалттай хогийн сав байршуулж, битүүмжлэл сайтай байлгах. Хогийн сав нь доорх шаардлагыг хангана.
 - Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн
 - Галд тэсвэртэй материалаар хийгдсэн
 - Хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн битүүмжлэлтэй
- ✓ Хог хаягдлыг зохистойгоор хаяж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажлын байрны шалгалт тогтмол явуулах, ажилчдад заавар зөвлөмж өгөх, зохих мэдлэгийг эзэмшүүлэх
- ✓ Орон нутагт жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгоор хог хаягдлыг тээвэрлэх, устгах зэрэг ажлуудыг гүйцэтгэх эрх бүхий орон

нутгийн компани, дүүргийн удирдлагатай хамтарсан гэрээ байгуулан хог хаягдлыг тогтмол хугацаанд тээвэрлүүлж байх.

- ✓ Дүүргийн Засаг даргаас тогтоож өгсөн, өөрийн байгууллагын хариуцсан 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын хог хаягдал цас мөсийг цэвэрлэх
- ✓ Эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаанд дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа наалгахгүй байх
- ✓ Үйлдвэрийн үйл ажиллагаанаас аюултай хог хаягдал гарсан тохиолдолд /шатахуун, шатах тослох материал, химийн бодисын сав, баглаа боодол, аккумулятор, дугуй г.м/- Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 23 дугаар зүйлд заасан хугацаанд аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалан, түүнийг устгах, дахин ашиглах тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулан ажиллах. Монгол улсын хэмжээнд хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 23 аж ахуй нэгж байдгаас гялгар уут, хуванцар, дугуй боловсруулах -7, аккумулятор боловсруулах -3, хаягдал тос боловсруулах -2 байгууллагууд байдаг байна.
- ✓ Аюултай хог хаягдал үүсгэгчээр бүртгүүлж, зарим хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалах тохиолдолд тусгай зөвшөөрөл авч, түр хадгалахдаа Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 33-р зүйлд заасан шаардлагыг баримтална.

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.	9.
1	Ахуйн	Хог хаягдал түр хадгалах цэгийг цементээр хучих болон хашаа хамгаалалт хийх	Хогийн цэг	м кв		-	Үйл ажиллагааны зардалд тусгах	2025 онд	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дугаар сарын 09-ны өдрийн А-116 дугаар тушаалын хавсралт “Хог хаягдлын тухай” хууль 10 дугаар зүйл, 14 дүгээр зүйл, 15 дугаар зүйл, 40 дүгээр зүйл MNS 5850:2019 MNS 5344 : 2011 MNS ISO 11074-1 : 2001
		Хог хаягдлыг ангилан ялгах	Төслийн талбайд			-	Үйл ажиллагааны зардалд тусгах	2025 онд	
		Ахуйн хатуу хог хаягдлыг зориулалтын цэгт нийлүүлэх (тээвэрлэх)	-	кг	-	-	500,000	2025 онд	
		Ангилан хаях зориулалттай хогийн савыг үйлдвэрт байрлуулах	Үйлдвэрийн орчин	ш	-	-	500,000	2025 онд	
2	Үйлдвэрлэлийн	Шатах тослох материалын хаягдал зориулалтын саванд	Төслийн орчим	л	Гэрээт компанид нийлүүлэх	-	Үйл ажиллагааны зардалд	2025 онд	

“Саус ресурс” ХХК-ийн Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт хэрэгжих “Хаягдал тос дахин боловсруулах үйлдвэр” төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		цуглуулж, хадгалах					тусгах		
		Техникийн хог хаягдлыг хадгалах цэг байгуулах, эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгөх	-	-	Эрх бүхий байгууллагад нийлүүлэх	-	500,000	2025 онд	
		Төмрийн хог хаягдлыг хаягдал төмөр авах цэгт нийлүүлэх	-	-		-	500,00	2025 онд	
3	Аюултай	“Цэцүүх трейд” ХХК-тай химийн бодисын сав баглаа боодол устгах гэрээ хийх	Төслийн хүрээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардалд тусгах	2025 онд	
	Нийт						2000,0		

7. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Төслийн явцад байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахтай холбоотой арга хэмжээг тухай бүрд авч хэрэгжүүлэх шаардлагатай. Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө холбогдох мэргэжлийн байгууллагаар Газрын чанарын улсын хянан баталгааг хийлгэх, цаашид 5 жил тутамд хийлгэх шаардлагатай. Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд холбогдох мэргэжлийн байгууллагаар хийлгэх шаардлагатай юм.

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
	1.	2.	3.	4.	5.	6.	7.
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	Ү/А зардалд	6 сар	11 сар		ХАБЭА-ын мэргэжилтэн	
2	Энгийн хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэхээр байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулан зөвшөөрөл авах	Ү/А зардалд	6 сар	11 сар		Байгаль орчны мэргэжилтэн	
3	Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарийг тогтоож, дүүргийн Засаг даргаар батлуулж мөрдөнө	Ү/А зардалд				ХАБЭА-ын мэргэжилтэн	
4	Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэлийн дагуу хог хаягдлын төрөл, кодыг тогтоон ялгаж бүртгэл хөтлөх	Ү/А зардалд				ХАБЭА-ын мэргэжилтэн	
5	БОАЖ-ын сайдын 2018 оны 02 дугаар сарын 02-ны А/21 дугаар тушаалын 3 дугаар хавсралтад заасан маягтын дагуу Аюултай хог хаягдал үүсгэгчийн тайлан мэдээг гаргаж аймагт жил бүр хүргүүлнэ	Ү/А зардалд	8 сард			Байгаль орчны мэргэжилтэн	
6	Гал унтраах хэрэгслээр үйлдвэрийн объектыг бүрэн хангах, гал түймэр унтраах талаар ажиллагсдыг сургах	Осол эрсдэлийн МТ-нд тусгагдсан				Байгаль орчны мэргэжилтэн	
7	Төслийн талбайд байгаль орчинтой зөв харьцах, хамгаалах талаарх мэдээлэл бүхий Байгаль орчны самбарыг байршуулах, мэдээллийг цаг тухай бүрд нь шинэчилж байх	500,000				Байгаль орчны мэргэжилтэн	
	Нийт	500,000					

8. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал (төгрөг)	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1.	2.	3.	4.	5.	6.	7.
1	Багийн ИНХ	Уулзалт санал асуулга	БОМТ болон Хяналт шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	10-р сар	Ү/А зардалд	“Саус ресурс” ХХК Байгаль орчны мэргэжилтэн	-
2	БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчны Бодлого зохицуулалтын газарт	-	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	11-р сар	Ү/А зардалд		-

9. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)


Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр тухайн төслийн нөлөөллийн болон нөлөөлөлд өртөж болзошгүй бүс нутагт гарах болзошгүй өөрчлөлтүүдийг эрт тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны үр дүнг илтгэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын байгууллага, нутгийн оршин суугчдад байгаль орчин, амьдрах орчны өөрчлөлтийн талаар бодит мэдээлэл өгөх үндсэн зорилготой.

ОХШХ-ийн хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд гаргаж төсөл хэрэгжиж буй тухайн орон нутаг түүний орчмын нутаг дэвсгэр дэх иргэдэд танилцуулах, сонирхогч талуудад мэдээллийг ил тод байлгах арга хэмжээг авсан байх шаардлагатай.

Хагас жил бүр орчны хяналт, шинжилгээний үзүүлэлтийг анхааралтай судалж өөрчлөлтийн үндсэн шалтгааныг тодорхойлон цаашид байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчин болон тухайн нутагт амьдардаг иргэдийг аливаа сөрөг нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг илүү үндэслэлтэй, тодорхой болгоход ашиглах шаардлагатай юм.

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Арга хэлбэр, хэрэглэх багаж төхөөрөмж	Нийт зардал (төг/жил)	Баримтлах стандарт ба арга, аргачлал
АГААРЫН ЧАНАР					
- Тоосжилт (PM₁₀, TSP, PM_{2.5}) - Гадаад болон дотоод орчны дуу чимээ, доргио, чичиргээ - Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг, чийгшил болон физик бохирдлын түвшин) - Бохирдлын цэгэн эх үүсвэр (O₂, SO₂, NO₂, CO)	Бохирдлын эх үүсвэрүүдийн байршлын салхины зонхилох чиглэлийн доор (хогийн цэг, дулаан хангамжийн дэд бүтэц, үйлдвэрийн орчим)	Жилд 2 удаа	Хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.	780,0	MNS 3113:1981. Байгаль орчныг хамгаалах. Агаар мандал. Агаарыг бохирдлыг бодисыг тодорхойлох аргад тавих ерөнхий шаардлага. MNS 5061:2001. Ажлын байрны агаар. Нүүрсхүчлийн хийн хэмжээг тодорхойлох. Эзлэхүүний арга. MNS 10012:2004 Хэмжилтийн удирдлагын тогтолцоо- Хэмжилтийн үйл явц ба хэмжих төхөөрөмжид тавих шаардлага
ХӨРСӨН БҮРХЭВЧ					
Хөрсний үржил шим, шинж чанар: Ялзмаг, урвалын орчин (pH), давсжилт, карбонат (CaCO₃), хөдөлгөөнт кали (K₂O), хөдөлгөөнт фосфор (P₂O₅), Шингээгдсэн сууриуд Ca, Mg	Хогийн цэг, үйлдвэр орчим, Зам, хяналтын цэг	Жилд 2 удаа	Итгэмжлэгдсэн лабораторийн задлан шинжилгээ	880,0	MNS 2305: 1995 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам, MNS 3298-1991 Байгаль хамгаалал хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Арга хэлбэр, хэрэглэх багаж төхөөрөмж	Нийт зардал (төг/жил)	Баримтлах стандарт ба арга, аргачлал
- Хөрсний ус, физик шинж чанар: Механик бүрэлдэхүүн, чулуу, чийг, амь чийг, эзлэхүүн жин - Хөрсний бохирдлын үзүүлэлтүүд: Хар тунгалаг (Pb), кадми (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni), Мөнгөн ус (Hg), цианид натри, хүнцэл (As) - Хөрсний эрүүл ахуй: 1 см³ дэх нийт бичил биетний тоо					MNS 5850:2008. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх
УСАН ОРЧИН					
- Усны химийн шинжилгээ (Ерөнхий хатуулаг, Урвалын орчин /рН/, Исэлдэх чанар, Тунгалагшил, Өнгө, Үнэр, Амт, Булингар, Тунадас, Анион Катион) - Ус бохирдлын үзүүлэлтүүд Хром (Cr), - Хөнгөн цагаан (Al), Хүнцэл (As), Кадмий (Cd), Кобальт (Co), Зэс (Cu), Хар тугалга (Pb) г.м	Унд ахуйн усанд	Жилд 2 удаа	Итгэмжлэгдсэн лабораторийн задлан шинжилгээ	100,0	- MNS 0900 : 2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
Нийт зардал / 5 жилээр/			1,760		



Зураг 2 Дээж авах мониторингийн цэгийн байршил